


Д.БАДАРЧ. “ДЭЭД БОЛОВСРОЛЫН ОНОЛ, АРГА ЗҮЙ:
ПАРАДИГМИЙН ШИЛЖИЛТ, БАГШЛАХУЙ, СУРАЛЦАХУЙ”
НОМЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

2021 оны 05 дугаар сарын 28
Онлайнаар ZOOM-ээр зохион байгуулагдана.



- **Зохион байгуулагчид:** БШУЯ-ны харьяа Боловсролын хүрээлэн, ШУТИС, Нээлттэй боловсролын төв
- **Хамрах хүрээ:** Дээд боловсролын чиглэлээр бодлого боловсруулагчид, судлаач, профессор, багш нар болон сонирхсон хүмүүс
- **Зорилго:** Номын талаарх үзэл бодол, туршлагаа хуваалцах, сонирхсон сэдвийн хүрээнд ярилцах, хэлэлцэх, түгээн дэлгэрүүлэх

ХӨТӨЛБӨР

ЦАГ	ҮЙЛ АЖИЛЛАГАА
10:30-11:00	БҮРТГЭЛ, ХОЛБОЛТЫН ТЕСТ
11:00-11:10	НЭЭЛТ, МЭНДЧИЛГЭЭ <i>Модератор: Боловсролын хүрээлэнгийн захирал, доктор П.Лхагвасүрэн ШУТИС-ийн захирал, доктор, профессор Б.Очирбат</i>
11:10-11:25	“ДЭЭД БОЛОВСРОЛЫН ОНОЛ, АРГА ЗҮЙ: ПАРАДИГМИЙН ШИЛЖИЛТ, БАГШЛАХУЙ, СУРАЛЦАХУЙ” НОМЫН ТАНИЛЦУУЛГА <i>ШУТИС-ийн захирал, профессор Б.Очирбат ШУТИС-ийн Нээлттэй боловсролын төвийн захирал Д.Ганбат</i>
11:25-12:25	ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, АСУУЛТ, ХАРИУЛТ Панелистууд: <ul style="list-style-type: none"> - Сурган хүмүүжүүлэх ухааны доктор, гавьяат багш Л. Жамц - ШУТИС-ийн ГУУС-ийн профессор Ж.Цэвээнжав - АШУҮИС-ийн дэд захирал, доктор Б. Дамдиндорж - ШУА-ийн Бага чуулганы гишүүн, шинжлэх ухааны доктор, профессор Ш. Ариунаа - ШУТИС-ийн МехТС-ийн дэд профессор Ш.Цоож
12:25-12:30	ХААЛТЫН ҮГ <i>ШУТИС-ийн Нээлттэй боловсролын төвийн зөвлөх, профессор Д.Бадарч</i>


НОМЫН ЗОХИОГЧ

ШУТИС-ийн Нээлтэй боловсролын төвийн зөвлөх, Дээд боловсролын судалгааны лабораторийн эрхлэгч, доктор, профессор Д.Бадарч



ШУТИС-д багшаас эхлэн ректор хүртэл 25 жил үр бүтээл, идэвх санаачилгатай ажиллан, их сургуулийн хөгжлийн орчин үеийн чиг хандлага, бодлого, стратегийг боловсруулан хөгжүүлж, сургалтын агуулга, технологи, материаллаг бааз, менежментийн шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлэн, дэлхийн дээд боловсролын сүлжээнд ШУТИС-ийг нэгтгэх ажлыг эхлүүлэн хэрэгжүүлж улмаар Монгол улсаас анх удаа НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (ЮНЕСКО)-д Д-1 зэрэглэлийн өндөр дээд албан тушаалд олон жил үр бүтээлтэй ажиллаж байсан бөгөөд боловсролын бодлого, удирдлага, засаглал, манлайлал, сургалтын нээлтэй нөөц материал, нийтийг хамарсан нээлтэй онлайн хичээл боловсруулах чиглэлээр судалгааны ажил гүйцэтгэж буй туршлагатай эрдэмтэн.

“ДЭЭД БОЛОВСРОЛЫН ОНОЛ АРГА ЗҮЙ” ЦУВРАЛЫН ДЭД ДЭВТЭР “ПАРАДИГМИЙН ШИЛЖИЛТ, БАГШЛАХУЙ, СУРАЛЦАХУЙ” НОМЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА



Дээд боловсролын онол, арга зүй цувралын энэхүү дэд дэвтэрээ зохиогч их, дээд сургуулийн багш нарт зориулсан бөгөөд боловсрол дахь парадигмийн шилжилт, суралцахуй, багшлахуйн орчин үеийн онол, арга, загваруудын талаар системтэйгээр тоймлон бичсэн байна. Сурган, сэтгэл судлалын асуудлыг нейросайнсын сүүлийн үеийн ололт амжилттай харьцуулан хүн мэдлэг хэрхэн олж авч, сурч мэддэг тухай асуудлыг боловсрол эзэмших хамгийн гол асуудал болгож тавьсан. Хүн бүр тархины үйл ажиллагааг сайн мэдэж байвал сурах үйл ажиллагааны үр өгөөж эрс дээшлэхийн зэрэгцээ боловсролын салбарт парадигмийн шилжилт хийх нөхцөл бүрдэх тул энэ номыг уншиж судалсан эрдэмтэн багш, боловсрол судлаач, бодлого тодорхойлогч та бүхэнд нэгийг бодогдуулж, цаашид тухайн сэдвүүдийг гүнзгийрүүлэн судлах хүсэл эрмэлзлийг төрүүлэх болно гэдэгт итгэж байна.

ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ПАНЕЛИСТУУД



**Монгол улсын
гавьяат багш
Л.Жамц**

Сурган хүмүүжүүлэх шинжлэх ухааны доктор, Монгол улсын тэргүүлэх зэргийн профессор, гавьяат багш. ЕБС-ийн физик, математикийн болон багш бэлтгэдэг их, дээд сургуулийн “Сурган хүмүүжүүлэх зүй”, “Сэтгэл судлал”, “Боловсрол судлал”-ын 40 гаруй сурах бичиг, гарын авлага, 100 гаруй эрдэм шинжилгээний өгүүлэл зэрэг 510 гаруй бүтээлтэй.



**ШУТИС-ийн
ГУУС-ийн Зөвлөх
профессор
Ж. Цэвээнжав**

ШУТИС-ийн Газрын тосны сургалт-судалгаа-мэдээллийн төвийн захирал, Техникийн ухааны доктор, профессор, зөвлөх инженер.

Эрдэс баялгийн мэргэжлийн чиглэлүүдээр 30 гаруй ном сурах бичиг, 600 гаруй өгүүлэл, илтгэл нийтлүүлсэн, эрдэм судлал, зөвлөх үйлчилгээний 10 гаруй тайланг үйлдвэрлэлд шилжүүлж, нэвтрүүлсэн. Шинжлэх ухаан танин мэдэхүйн 200 шахам материал нийтлүүлсэн.



**АУУИС-ийн Эрдэм
шинжилгээ, гадаад
харилцаа
хариуцсан дэд
захирал
Б.Дамдиндорж**

Анагаах ухааны үндэсний их сургуулийн Эрдэм шинжилгээ, гадаад харилцаа хариуцсан дэд захирал, анагаах ухааны доктор (Ph.D.)

2010-2012 онд Япон улсын Жичи Анагаах ухааны их сургуульд Тархи судлалын чиглэлээр докторын дараах сургалтыг дүүргэсэн. Судалгааны чиглэлээрээ 20 гаруй эрдэм шинжилгээний өгүүлийг хэвлүүлсэн байна.



**ШУА-ийн Бага
чуулганы гишүүн,
шинжлэх ухааны
доктор, профессор
Ш. Ариунаа**

Философич, багш мэргэжилтэй. ОХУ-ын ШУА-ийн Философийн хүрээлэнд доктор (Ph.D) болон Шинжлэх ухааны докторын (Sc.D) зэргээ хамгаалсан.

Эрдэм, судлалын үр дүнгээр гадаад хэлээр 2 монограф, монгол хэлээр 17 гарын авлага, сурах бичиг, хамтын 11 бүтээлийн бүлэг, зүйл, монгол, гадаад хэлээр эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл 74-ийг бичиж хэвлүүлсний 17- нь хянан магадалгаа бүхий сэтгүүлд хэвлэгдсэн.



**ШУТИС-ийн
МехТС-ийн дэд
профессор Ш.Цоож**

Механик инженер, Тайвань улсад 2017 онд “Программын удирдлагатай суурь машины боловсруулалтын нарийвчлал болон энергийн үр ашгийг тооцох ухаалаг оновчлолын систем” сэдвээр доктор (PhD) зэрэг хамгаалсан. Мэргэжлийн болон сурган заах зүйн чиглэлээр гадаад, дотоодын мэргэжлийн сэтгүүлд 10 гаруй эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлж, дотоодын болон олон улсын 10 гаруй төсөлд оролцож, Монгол улсын 5 стандарт боловсруулж батлуулахад ажилласан.